**БАТЛАВ.**

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА, БРИГАДЫН ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

"МӨНХИЙН ТУН" ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ц.АЛТАНЦЭЦЭГ

# БАРАА, МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр | Дугаар 85 | Улаанбаатар хот

1. Нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар (цаашид "захиалагч" гэх)-ыг төлөөлж Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын дарга, дэд хурандаа Ч.Цогбаяр, нөгөө талаас "Мөнхийн тун" ХХК (цаашид "Нийлүүлэгч" гэх)-ийг төлөөлж эдийн засагч М. Алтангэрэл нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

2. Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, болон бусад хууль тогтоомжийн дагуу 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд шинэ коронавирус /Ковид-19/-ийн цар тахлын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд сонгогчид болон сонгуулийн байранд ажиллах албан хаагчдад шаардлагатай бараа, материалыг бүрдүүлэх /цаашид "бараа, материал" гэх/-тэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

3. Энэхүү гэрээгэр 1.549.894 ширхэг нэг удаагийн амны хаалт үнэ, чанар стандарт, нийлүүлэх хугацаа, байршлыг эцэслэн тохирох үндэслэл болно.

4. Нийлүүлэх барааны үнэ:

| Барааны нэр | Гарал үүсэл | Хэмжих нэгж | Тоо, ширхэг | Нэгж үнэ | Мөнгөн дүн |
|---|---|---|---|---|---|
| Нэг удаагийн амны хаалт | Монгол | ширхэг | 1.549.894 | 650 | 1.007.431.100 |
| **Дүн** | | | **1.549.894** | | **1.007.431.100** |

5. Захиалагч нь бараа нийлүүлэлтийг Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлнэ.

6. Нийлүүлэгч хавсралтад заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан нэг удаагийн амны хаалт 1.549.894 ширхэгийг 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Улаанбаатар хот дахь Улсын нөөцийн салбарт хүргэж хүлээлгэн өгнө.

7. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний бичиг баримт" гэх). Үүнд:

- Гэрээний ерөнхий нөхцөл /1 дүгээр хавсралт/
- Гэрээний тусгай нөхцөл /2 дугаар хавсралт/
- Техникийн тодорхойлолт /3 дугаар хавсралт/
- Бараа, материал нийлүүлэлтийн болон санхүүжилтийн хуваарь /4 дүгээр хавсралт/

8. Гэрээ нь энд дурьдсан бараа, материал нийлүүлэх талаархи талуудын хоорондын бүрэн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

9. Захиалагч, нийлүүлэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

10. Нийлүүлэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан бараа, материалыг нийлүүлж, зөрчил, доголдлыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

11. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа, материал бо доголдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.

12. Захиалагчийг төлөөлөн үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцож ба албан хаагч болон гэрээ хэрэгжүүлэгч бүр бараа худалдан авах ажиллагаан захиалагчийн гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин сонирхлын зөрчилгүй байна. Зөрчил үүссэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу эр т авна.

13. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Ч.ЦОГБАЯР

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"МӨНХИЙ ТУН" ХХК-ИЙН ЭДИЙН

М.АЛТАНГЭ

Улаанбаатар хот, СБДүүрэг,
Партизаны гудамж-6

Утас/ факс: 51-263399
Төрийн сан 100900031005
Регистрийн дугаар: 9129146

Улаанбаатар хот, Баянзүрх
16-р хороо, Эрдэнэтолгой,
сургуулийн гудамж-1
Утас/факс: 70115653, 70135
Хаан банк: 5011318210
Регистрийн дугаар: 2024608

## ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 06 дугаар сарын 15 Улаанбаатар хот

Онцгой байдлын ерөнхий газар, “Мөнхийн Тун” ХХК-ийн хооронд 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан 85 дугаар гэрээний хэрэгжилтийг хоёр тал хамтран дүгнэв.

2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр гэрээнд заасан нэг удаагийн амны хаалт – 1.549.894 ширхэгийг Улаанбаатар хот дахь Улсын нөөцийн “Обьект- 03” салбарын агуулахад хүлээлгэн өгсөн тухай.

| Барааны нэр | Х/н | Гэрээний дагуу нийлүүлэх тоо | Гүйцэтгэлээр: | | | Олгох /төгрөг / |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Нийлүүл сэн тоо | Нэгж үнэ | Бүгд үнэ /төгрөгөөр/ | |
| Нэг удаагийн амны хаалт | ш | 1.549.894 | 1.549.894 | 650 | 1.007.431.100 | **1.007.431.100** /нэг тэрбум долоон сая дөрвөн зуун гучин нэгэн мянга нэг зуун/ төгрөг |
| **Дүн** | | **1.549.894** | **1.549.894** | | **1.007.431.100** | |

2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд шинэ коронавирус /Ковид-19/-ийн цар тахлын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд сонгогчид болон сонгуулийн байранд ажиллах албан хаагчдад шаардлагатай 1.549.894 ширхэг нэг удаагийн амны хаалтыг гэрээнд заагдсан хугацаанд техникийн тодорхойлолтын шаардлага болон гэрээний бусад нөхцлийг бүрэн хангаж хүлээлгэн өгсөн тул гэрээний биелэлтийг хангалттай гэж 2 тал үзлээ.

**ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:**

**ОБЕГ-ыг төлөөлж:**

Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газрын дарга, дэд хурандаа
Ч.Цогбаяр

УНХТГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн хэлтсийн дарга, хурандаа
С.Лхагвасүрэн

УНХТГ-ын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа
М.Хаш-Эрдэнэ

**“МӨНХИЙН ТУН” ХХК-ИЙН төлөөлж:**

Захирал
Ц.Алтанцэцэг

Менежер
М.Алтангэрэл

ОБЕГ-ын даргын 2010 оны 217 дугаар
тушаалаар батлагдсан журмын 1 дүгээр хавсралт

# УЛСЫН НӨӨЦӨД БАРАА, МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВСАН АКТ №

2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ОБЕГ-ын харъяа 185 дугаар салбар
(Улсын нөөцийн салбар)

"Мөнхийн тун" ХХК
(Бэлтгэн нийлүүлэгчийн нэр)

63-57 УНЧ истана Тогосоо, 35-90 УБЦ
Сүхбаатар

РД: 2024608

Акт нь орлогын баримтын хамт хүчинтэй

Орлогын баримтын №...........

| № | Барааны нэр | Хэмжих нэгж | Тоо | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нэг удаагийн амны хаалт | ширхэг | 1,549,894 | 650.00 | 1,007,431,100.00 |
| | **Бүгд дүн** | | | | **1,007,431,100.00** |

**Барааны чанар байдлын талаар:** "Мөнхийн тун" ХХК-аас нийлүүлсэн хамгаалах хэрэгсэл нь гэрээнд заасан техникийн тодорхойлолтын дагуу чанар стандартын шаардлага хангасан болно.

**Гэрээний үүргээ хэрхэн биелүүлсэн талаар:** Гэрээнд заасан хугацаанд чанар стандартын шаардлага хангасан хамгаалах хэрэгсэл нийлүүлсэн тул гэрээний үүргийг 100 хувь биелүүлсэн гэж үзэв.

**Хүлээн авсан:**

ОБЕГ-ын харъяа 185 дугаар салбарын ахлах нягтлан бодогч
Ахлах дэслэгч ......................................../С.Өлзийбаатар/

ОБЕГ-ын харъяа 185 дугаар салбарын нөөцийн барааны нярав
Дэд ахлагч ......................................../А.Отгонжаргал/

**Хүлээлгэн өгсөн:**

"Мөнхийн тун" ХХК-ны Тун фарм эмийн үйлдвэрийн
захирал ......................................../М.Хад-Эрдэнэ/

**Шалгасан:**

ОБЕГ-ын харъяа 185 дугаар салбарын дарга
Хошууч......................................../Б.Ганбат/